




## ДӨРВӨД АРДЫН ДУУНЫ ОНЦЛОГ, ӨВЛҮҮЛЭХ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

ЛМУСИ<sup>а</sup>, Ч.Отгонбаяр<sup>б</sup>,  
<sup>а</sup>ӨМӨЗО-ны Улаанцав хотын Дөрвөд хошууны сурган хүмүүжлийн товчоо бичээч;  
<sup>б</sup>МУБИС-Багшийн сургууль, багш, доктор

Холбоо барих зохиогч: а)WeChat ID:wxid\_kf171ylnua2s22 б)otgonbayar.ch@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2023.11.12

Хянагдсан: 2023.12.12

Зөвшөөрсөн: 2023.12.25

### Хураангуй

Дөрвөд бол эртний Монгол угсаатан, ойн иргэдийн нэгэн. Ойрадын Зүүн гарын хаант улсын гол аймаг, Богд хаант Монгол улсын үеийн Ховд хязгаарын зонхилох ястан юм.

Дөрвөд - Монгол үндэстний ястан, Ойрад аялгатай, монгол хэлтэн. Дөрвөд нь 1400-1755 оны хооронд тогтносон Дөрвөн Ойрадын дөрвөн гол аймгийн нэг нь байв. БНХАУ-ын Хар мөрөн муж (Өвөр Монгол, ОХУ-ын Владивосток болон БНАСАУ-ын хооронд орших муж)-ийн Дачин хотын Дөрвөд Монголын өөртөө засах хошуун (Мужийнхаа баруун хойт тал)-д дөрвөд ястан бөөнөөрөө орших бөгөөд эдгээрийг дөрвөдүүд Енисей мөрнөөс Халх гол, Байгаль нуур луу 11 дүгээр зуунд нүүдэллэн ирж нутаглаж байгаад баруун тийш нүүх үед тасран үлдсэн гэж үздэг. Түүнчлэн Өвөр Монголын Улаанцав хотын Дөрвөд хошуунд (18 мянга орчим) мөн Хөхнуур мужийн Хошуунд Монголчуудын дунд дөрвөдүүд амьдарч байна.

### Түлхүүр үг

Дөрвөд ардын дуу, соёл, судалгаа, сургалт, үр дүн

### Удиртгал

Өвөр Монголын Дөрвөд хошуунд ардын дууг сэргээх ажил жил бүр зохион байгуулагддаг ч судалгааны бүтээл ном товхимол ховор байна. Дөрвөдүүдийн төрөл бүрийн зан үйл, эрт үеэс уламжлагдаж ирсэн өв уламжлал баяр наадмууд нь тэдний амьдралд хэрэглэгдэх нь багасаж, улмаар өв соёл, зан заншил нь мартагдаж байна. Иймд Дөрвөд ардын дууны ая хөг, онцлогийг гаргасан судалгаа хийж, биет бус соёлын өвийн ач холбогдол болоод мөн чанарыг сурталчлан таниулах, зааж сургах, хамгаалан, хөгжүүлэх зорилгоор энэхүү сэдвийг сонгосон болно.

Бидний судалгааны ажил дөрвөд угсаатны талаар түүхийн судар бичиг, мэдээлэл дээр үндэслэн гарал үүсэл, соёл, ёс заншил, ялангуяа дөрвөд ардын дууны дуулах арга барил, түүнийг хүүхэд залуучуудад заан сургах, өвлүүлэхэд оршино. Тухайн судалгааны ажлыг аман болон түүхэн судалгааны эх сурвалж бичиг, ном зохиол, эрдэмтэн судлаачдын бүтээлийг уншин судалж, түүхэн судалгааны түгээмэл аргууд болон, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших гэх мэт аргуудыг сонгон хэрэглэсэн ба “Дөрвөд” хэмээх угсаатны дуу хуурын аялгууны онцлог, тэр тусмаа ардын дууны онцлогийг гаргаж суралцагчдад ойлгуулах, урын сангийн баялагтай болгож өвлүүлж байгаа нь шинэлэг тал болно.

Дөрвөд нутгийн түүх, мартагдаж байгаа өв соёлоос залгамжилж цаашид хойч үедээ судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож үлдээж ач холбогдолтой хэмээн үзэж байгаа юм.

Өвөр Монголын Улаанцав хотын Дөрвөд хошууны засгаас эмхэтгэн хэвлүүлсэн “Дөрвөд ардын дууны сонгомол” номд 102 дөрвөд ардын дууг багтааж ноот, шүлгийг хятад монголоор хадаж оруулсан байдаг. Мөн Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос бэлтгэн гаргасан “Монгол ардын дуу 500” номд цахар, дөрвөдийн дуу хэмээн нэг бүлэг багтсан байдаг.

Монголын Нууц Товчооны 11-р зүйлд Дува сохорын 4 хөвүүнийг Добу мэргэн ахаас салж «дөрвөн овогтон» болов гэж бичсэн байдаг. Дөрвөд гэдэг нь Дөрвөн-ий олон тоо юм. Энэ нь 9 дүгээр зууны эцэс, 10 дугаар зууны үед хамаарах явдал гэж үздэг. Мөн Абулгази хан өөрийн ургийн бичигтээ «Бөртэ Чонын хүү Хоо марал түүний хүү Бэчин хиан, тэр 5 хүүтэй ба бага түү Тамачиг илүү хайрлах тул том 4 хүү нь гомдож харийн нутаг руу нүүж, тэднийг Дөрвөн гэж дуудах болов» хэмээн бичжээ. Энэ нь 8 дугаар зууны эцэс, 9 дүгээр зууны эхэн үед хамаарах явдал гэж үздэг. Дээрх баримтууд дөрвөдийг Хиадаас салбарласан язгуурын Монгол овог гэдгийг баталдаг. 12 дугаар зуунд Дөрвөн овогтон Дарлигин Монголын дотор багтаж байв. Чингис хааны дараах үед дөрвөдүүд Алтай болон Ил тарвагатайд очиж нутагласан ажээ. Нэгэн үе бүх Монголыг нэгтгэн захирч их хаан ширээнд суусан ойрадын Эсэн тайш өөрийн ууган хүү Борнагалд дөрвөдүүдийг өгч захируулсан бөгөөд дөрвөдийн ноёд түүний удмын хүмүүс байдаг.

Мөн БНХАУ-ын Хар мөрөн муж (Өвөрмонгол, ОХУ-ын Владивосток болон БНАСАУ-ын хооронд орших муж)-ийн Дачин хотын Дөрвөд Монголын өөртөө засах хошуун (Мужийнхаа баруун хойт тал)-д дөрвөд ястан бөөнөөрөө орших бөгөөд эдгээрийг дөрвөдүүд Енисей мөрнөөс Халх гол, Байгаль нуур луу 11 дүгээр зуунд нүүдэллэн ирж нутаглаж байгаад баруун тийш нүүх үед тасран үлдсэн гэж үздэг.

Түүнчлэн Өвөрмонголын Улаанцав хотын Дөрвөд хошуунд (18 мянга орчим), мөн Хөхнуур мужийн Хошууд монголчуудын дунд дөрвөдүүд амьдарч байна. 17 дугаар зууны үед Ойрадуудыг Манжаас хамгаалахын тулд торгууд, дөрвөд, өөлдүүдээс сайн эрсийг шилж гэр бүлээр нь захлуулан амьдруулснаар одоогийн захчин ястан бий болсон.

## Үндсэн хэсэг Дөрвөд угсаатны ардын дууны онцлог

Монгол ардын дууны аялгууны онцлогийг судлах үндсэн материал нь ардын авьяастны дуулсан дуу хуурын бичлэг, түүнийг тэмдэглэн авсан ардын урлаг судлаачийн хөгжмөн бичиг болсон ноот тэмдэглэгээ билээ.

Монгол дууг ноот бичигт буулгах ажил Оросын монгол судлагч нараас анх үүдсэн ба “Монгол овогтнуудын аялгуу” (Мелодии Монгольских племён) хэмээх бүтээлийг Оросын Монгол судлаач А.Д.Руднеев (1878-1958) анх 1909 онд хэвлүүлж байжээ. Энэ нь орос судлаачдын монгол дуу хуурын бүтээлийг хөгжмийн бичигт тэмдэглэсэн анхны бүтээл юм. 1933 онд П.М.Берлинскийн (1900-1976) “Монголын дууч, хөгжимчин Өлзийн Лувсан хуурч” гэдэг ном туурвисан нь Монгол уртын болон ардын дууны нэлээд ноот багтсан байна. 1971 онд Б.Смирновын (1912-1971) “Монгольская народная музыка” хэмээх номонд Монголын 200 орчим ардын дуу хөгжмийг ноотлон багтаасан нь өнөө ч гайхагдам бүтээл гэгдсээр байна.

Монголчууд өөрсдөө санаачилж, уртын болон ардын дуунуудаа Европын ноот бичигт буулгасан анхан бүтээл нь 1935, 1936 онуудад хэвлэгдсэн “Монгол дуунуудын түүвэр”, “Монголын урт дуунуудын түүвэр” гэсэн хоёр ном болно. Энэ цагаас хойш хэдэн арав, зуугаар тоологдох монгол дууны түүврүүд гарсан хэдий ч Монголын олон ястан, угсаатны нэгэн болох дөрвөдийн ардын дууны түүврүүд хөгжмийн нооттойгоо хэвлэгдэн гарсан нь нэн ховор байна.

Угсаатны болон ардын дууны судлалын ном бүтээлүүдэд дөрвөд угсаатны дуу хөгжмийн тэр дундаа ардын дууг хөгжмийн ноот бичигт буулгасан тэмдэглэл тун бага тохиолдож байв. Маш ховорхон олдох дөрвөд уртын дууны ноот тэмдэглэгээний хувьд буруу, ерөнхий тоймлосон шинжтэй байсан нь тухайн ястны уртын дууны хөгжмийн өнгө, төрхийг тодруулан судлахад судлаачдад бэрхшээлтэй байсан.

Дөрвөдүүдийн олон мянган жилийн турш өвлөн ирсэн Монгол уламжлалын нэгээхэн хэсэг нь хурим, найрын зан үйл юм. Дөрвөдийн ураг барилдах ёсны эртний нэг журам бол хүүдээ 14-15 наснаас нь бэр гуйх явдал бөгөөд түүхийн тулгуураас үзэхэд Чингис хаан Хутага–Бэхид охидыг богтлон өгч байсан мэдээ байдаг ба энэ нь бүр дээр үеийн богтлох ёсны үлдэц хэмээн хэлж болох юм. Дөрвөдийн уламжлалт гэрлэх ёс, зан үйлийг уртын дуугүйгээр төсөөлөхийн аргагүй бөгөөд эрт дээр үеэс өнөөг хүртэл уртын дууг дуулах гол тайз нь айл гэрийн хурим, найр байсан. Тиймээс: Тохох эмээлгүй, унах унаагүй эрийг эр гэж тооцдоггүйн адил, Дуулах дуугүй, дуугарах дугараагүй найрыг найр гэж үздэггүй байжээ (Катуу, 1995). Хурим найрын дуу нь:

1. Хурим найрын дэг журам хүндэтгэлийг илэрхийлсэн.
2. Ард түмний ертөнцийг үзэх үзэл, шүтлэг бишрэл, бэлгэдлийг багтаасан.
3. Найрлагчид, гийчдийн ая тухыг алдагдуулахгүй байх, найрлан цэнгэхийг уриалсан утгыг илэрхийлсэн.
4. Тухайн зан үйлийнхээ утга агуулга, онцлогийг тусгасан.
5. Сурган хүмүүжүүлэх зүйн болон ёс суртахууны бүрдлийг багтаадгаараа бусад дуунуудаас онцлог юм.

Хуучнаар Дөрвөдийн Далай ханы хошуунд сайн дуучнаа **Хурлаа дууч** хэмээн хүндэтгэж гадны хошууны найр наадамд тусгайлан дагуулж явах ба хүчит бөх, сайн морины адилаар хооронд нь өрсөлдүүлдэг байжээ. Алдартай сайн дуучид дуу

давтахгүй, дуу таслахгүйгээр 5-6 өдөр дуулж чаддаг байжээ.

Дөрвөдийн найр хуриманд найрын дуучин нь дараах дэг ёсыг баримталж байв.

- Согтголоо архи ууж болохгүй.
- Дуу дутуу дуулах ёсгүй.
- Дуу дуулж байхдаа суудал сольж болохгүй /чөмөг солихгүй/.
- Дуугаа баруун зүүн тал ээлжлэн ая шилжүүлж дуулах гэх мэт...

Дөрвөдийн хуримын дууны утга санаа, зориулалтыг харгалзан

- Хуримын эхэн дуу - Хурим хөгжөөх дуу - Хурим жаргаах дуу -Хурим найранд дуулахыг хориглох дуу гэсэн 4 хэсэгт хувааж болно.

Хуримын эхэн дуу: Дөрвөдийн «Тэвш өргөх найр»-ын ёслолд хүүгийн талаас хүүхний юм ачиж нрэх тэмээ хомнон, хүүхний унаж ирэх морийг нь суран ногтоор ногтлон эмээлгүй хөтлөөд өлөн гэдсэнд нь долоон хоргол үлдээж зангидсан хонины бүхэл мах, мөн хонины тураг мах тэвшинд хийж архи, айраг авч очно. Ингээд мах, идээ, айраг, архиа гарган «Тэвш өргөх найр»- аа хийнэ. Өргөл барьцыг хүлээн авсны дараа хадам аав нь аягатай архи барьж ерөөл тавьж дуусаад архиа уухад найрлагедын хэн нэгээс нь эхлэн **“Хөх тохой нутаг”** дууг дуулахад хүүгийн талаас **“Ардаг баахан шарга”**дууг дуулж дараа нь хадам эцэг, эх нь **«Ут сайхан хүрэн»** зэрэг дууг дуулдаг байна. Бэр буулгах ёслолын үеийн бас нэг жижиг ёслол бол найрын эхэн үеэр болдог хүргэн цагаалуулах ёс юм. Хүргэн хүү хадам эцэг, эх, бусад ах дүүгийн хүмүүст хадаг барьж тэдэнтэй золгодог ёслол. Энэ үеэр хүүхний ээж модон аяганд сүү хийж хадган дээр тавин хүргэн хүүд барьж гар бэлэг барьдаг байна. (Орших, 2016.).

Энд бид судалгааныхаа эхэн үед олж авсан Дөрвөд ардын дууны ноотыг дэлгэн үзүүлж байна. Бидэнд анхандаа хэн тэмдэглэсэн нь үл мэдэгдэх Дөрвөдийн “Гишгэдэл сайтай хээр”, “Нарьхан саарал морин”, “Уринаа сайхан бор”, “Улаанаа бор морин”, “Сэтэрт баахан шарга”, “Кээр халтар морин”, “Өндөр көкөөн өвөр”, “Нарин баахан кээр”, “Өндөр заагийн шил”, “Ар күрэнгээн шил”, “Будлан уул”, “Цагаан тохаа нутаг”, “Арван гурван сайхан” зэрэг дөрвөд уртын дууны ноот олдсон болно. Тухайбал

Ноотны жишээ 1: Цагаан тохой нутаг



Жишээлэн харуулсан дөрвөд ардын дуунуудын ноотон дээр ажиллаж тухайн дуунуудын онцлогийг гаргаж ирэх боломж бараг байхгүй байсан. Учир нь Дөрвөд ардын дууг тэмдэглэн нотлохдоо тухайн дууныхаа эгшиг томлолт, цохилго болон аялгууны гол суурь өнгөнүүдийг тэмдэглэсэн байдал нь дутуу, ерөнхийлсөн, зарим бичилт нь буруу байсан.

Дөрвөд ардын дууны ялгарамжит төрх байдлыг зураглан үзүүлж, дөрвөд ардын

дууны аялгууны онцлог шинжийг шинжлэн судалж, тандан гаргах зорилгоор Дөрвөд дууны далай мэт сангаас сонгон авч, цараа буюу диапозон, өрөг-өнгө хооронд ямар ямар интервалууд илүү их зонхилж байгаа зэрэг статистик судалгаа хийлээ.

“Хөх мөнгөн тэнгэр” дуу нь дөрвөд ардын найрын дуу нь Юан тайзугийн дүү Хавт Хасарын 15-дугаар үеийн ач ноёнттой, отгон ноён ах хөндлөн тайжтайгаа, Хөлөн буйрын тал нутагт оторлон малжиж байхдаа ардын дунд дуулагдаж байсан найрын дуу юм. Хөх мөнгөн тэнгэр дөрвөд ардын найрын дуу нь 13 үеийн 15 вангийн үе залгамжилснаас эдүгээ хүртэл дуулагдаж ирсэн гэдэг.


Ноотны жишээ 2:

Хөх мөнгөн тэнгэр



Хөх л мөнгөн тэнгэр минь дээ хөө  
Хүйтэнгүй дулахан байгаасай  
Хөрст алтан дэлхий минь дээ хөө  
холгүй ойрхон байгаасай.

Ноотны жишээ 3: Дөрвөд ардын дуу -Цаст цагаан уул



Баруун ч булгийн ус л мэт тунгалаг  
Бадамлянхуа цэцэг мэт сэргэлэн  
Багын ерөөлөөр учирсан ах дүү тандаа хө  
Багаахан хэмээрээ байн байн зооглуулъя хө

Цаст цагаан уул дуу нь 3 бемольтой Си бемоль мажорын тональностод бичигдсэн. 4/2 хэмжээтэй, синкоп ихтэй байгаа нь тухайн дууны утга агуулгыг хоолойн донжоор гаргаж дуулахад зориулагдсан мэт харагдаж байна. 8-р тактанд 1р октавын си b -иос бага октавын си b руу октавын зайтай үсэрч байгаа нь хоолойн чадал, багтаамжийг нээх шаардахгүй дуучдын хоолойд тохирсон аль ч насны хүн дуулахад боломжтой. Ноотны жишээ 4: Дөрвөд ардын дуу “Жороо бор”



Хаврын хаваржаа нь хө

Хадат ухаагийн энгэрт  
Халамжит олон та нартайгаа  
Хамтаар найрлан жаргая

Дөрвөд ардын дуу “Жороо бор” дууны ноотыг анализ хийж үзвэл: Дээрх дуутай адил 3 бемольтой ч до минорын дуу. 4/3 хэмжээтэй, цэгтэй ноот, 16-8 ноотууд нь үг, аялгууг тодруулж, өгүүлэх хүүрнэх санааг илэрхийлсэн хөнгөн хэмнэлүүдээс бүрдсэн гэж үзэж болохоор байна. Дөрвөдчүүд уламжлалт ардын дуугаа хадгалж авч явах, түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх үүднээс жил бүр Дөрвөд ардыг дууны уралдаан зохион байгуулдаг.

Мөн дөрвөдүүд жил бүрийн цагаан сарын үдэшлэг, баярын нэвтрүүлэг хийж Өвөр Монголын Одон телевизэд бичүүлж өв соёлоо сурталчилдаг.

### Судалгааны үр дүн:

Дөрвөд хошууны Монгол дундад сургуулийн өндөр дэсийн багш Гэнсгэдалай нь сурлагын жилийн доод хугацаа буюу хаврын улиралд сургалтын хөтөлбөрийн дагуу агуулгын алдагдалгүйгээр Дөрвөд ардын “ Дорно дахины сувд”, “Үүлэн доторх цайз”, “Чидун мод” ..зэрэг 6 дууг сонгон зааж сургаснаар сургууль, хүүхэд, эцэг эх, багш нарт өндөрөөр үнэлэгдсэн. Дууг заахдаа дуулах үйл ажиллагааны үйлээр багшийг сонсох, бие биенээ сонсох, үгийн утгыг тайларлах, даган дуулах, хамтаар дуулах зэрэг аргуудыг хэрэглэсэн. Тухайлбал:

- Багш өөрөө дуулж үгийн хуваарийг сонсож, амьсгаа авах хэсэгт тэмдэглэгээ хийлгэх
- Дууны аялгууны хурд, хэмжээг тохируулан дуулах зэргийг анхааруулах
- Дууныхаа аяыг мөр мөрөөр нь дагуулан дуулуулж сургах
- Дууны үг аялгууг сайн сурсны дараа хэмжээ хэмнэлд нь тохируулан хөдөлгөөн хийж бүжиглэн дуулах
- Дууны утга агуулгыг дүрслэн зурж, өнгө будгаар ялгах
- Дууг анги хамт олноороо, хамтлагаар, гоцлолоор зөв сайхон дуулж, бүжиглэх гэх мэт. Үр дүнг дараах судалгаагаар харуулбал:

Хүснэгт 1: Дөрвөд хошууны Монгол үндэстний дунд сургуулийн 8а ангийн сурагчдын Дөрвөд ардын дууг хэрхэн сурсан судалгаа / 1-5оноо/

№	Суралцагчдын нэрс	Дээд				1-р хагасын үнэлгээ	Доод			2-р хагасын үнэлгээ
		Ардын дууны дуулах арга барил онол	Хөх мөнгөн тэнгэр	Цаст цагаан уул	Дөрвөлжиндөө зуссан нь		Жороо бор	Дэлгэр сайхан хангай	Их нарны гэрэл	
1	Аварга	4	3	3	4	10	3	4	4	11
2	Алиа	5	4	4	4	12	4	5	5	14
3	Аснаа	5	3	4	5	12	4	5	5	14
4	Баатар	4	2	4	4	10	4	4	5	13
5	Батжаргал	3	3	3	4	10	4	4	5	13
6	Баяраа	4	4	4	4	12	4	5	5	14
7	Бүрэн	3	3	4	4	11	4	4	4	12

8	Гэгээнзүл	3	4	4	4	12	4	4	4	12
9	Гэгээнцэр	4	4	4	4	12	4	5	5	14
10	Гэрэлт	3	3	4	4	11	4	4	5	13
11	Гэндэнжав	4	4	4	5	13	5	5	5	15
12	Давхарбаяр	4	4	4	4	12	5	5	4	14
13	Далантай	3	3	4	4	11	4	4	4	12
14	Дуулим	3	3	4	4	11	4	4	4	12
15	Дулаанаа	4	4	4	5	13	5	5	5	15
16	Дэлгэр	4	3	4	4	11	4	4	4	12
17	Жимсээ	5	4	4	5	13	5	5	5	15
18	Заяа	3	3	3	4	10	4	4	4	12
19	Жаргал	4	2	3	4	9	3	4	4	11
20	Мандах	4	4	5	5	14	4	5	5	14
21	Налайнаа	5	5	5	5	15	5	5	5	15
22	Намараа	3	3	3	4	10	4	4	4	12
23	Саруул	4	4	4	4	12	4	4	5	13
24	Сайханаа	4	3	4	5	12	5	5	5	15
25	Эрдэм	5	4	4	5	13	5	5	5	15
26	Энхзаяа	5	5	4	5	14	5	5	5	15
Бүгд оноо		130	130	130	130	390	130	130	130	390
Авсан оноо		102	91	101	111	305	110	117	120	347

Дөрвөд ардын дууны онцлог, дуулах зан үйл, арга барилаас судалсан зүйлдээ тулгуурлан хүүхдийн нас сэтгэхүй онцлогт тохируулан 8-р ангид ардын дууг хэрхэн заах, дуулуулж сургах, өвлүүлэн үлдээх боломжийг харгалзан онцлон ажилласан болно. Эндээс харахад дөрвөд ардын дууг сонгож дуу хөгжмийн хичээлээр заахад хүүхдүүд сайн сурч байна. Мөн цаашид ардын сурсан дуугаа мартажгүй нэгэн насны өв болно гэж үзлээ. Дөрвөд ардын дууны өвлөн уламжлагч Улсын хоёрдугаар дэсийн тоглогч, ургын дууны багш Жимсээ өөрийн сургалтын хүрээнд энэхүү илтгэлийг бичсэн болно.

Хүснэгт 2: Жимсээгийн “Ардын дуу дуулах арга зүй” хичээлийн хөтөлбөр /дамжаа-1/

№	Сургалтын агуулга	Хугацаа	Хамрах хүрээ	Багшийн тайлбар
1	Хөгжмийн онолын хэллэг нэр томьёо	Зуны сургалт 2021-7-12-ноос 8-р сарын 1 хүртэл хичээллэнэ	16-34 насны хоорондох дунд, ахлах ангийн сурагч, оюутан, ажилтан, жүжигчид байна.	Энэхүү 21 хоногийн хугацаанд 16-34 насны 9 хүүхдүүдийн ирц, идэвх оролцоо сайн байж амжилттай суралцсан.  Иймээс 2-р шатны дамжаанд бүгд суралцахаар дахин гүнзгийрүүлэн хичээллэсэн.
2	Хөгжмийн хэм хэмнэл			
3	Хувиргалын тэмдэг			
4	Хүчдэлийн тухай			
5	Хэллэг хөгжүүлэх дасгал			
6	Амьсгал хөгжүүлэх дасгал			
7	Ардын дууны ач холбогдол			
8	Ардын дууны өв тээгчдийн намтар түүх			
9	Хоолойн багтаамж, өнгө тогтоох дасгал			
10	Уухай			
11	Нугалаа хийх дасгал			
12	Хоолойн цараа хөгжүүлэх дасгал			
13	Ардын дууны төрөл ангилал			
14	Ардын богино дуу дуулах арга зүй			
15	Ардын богино дуу дуулах арга зүй-Урын сантай ажиллах			
16	Урын сантай ажиллах			
17	Бэсрэг ургын дуутай ажиллах арга зүй			
18	БУД, Дөрвөн настай халиун			
19	БУД, Дөрвөн настай халиун			
20	Хөх мөнгөн тэнгэр			
21	Хөх мөнгөн тэнгэр			

Хүснэгт 3: 2-р дамжааны сургалтын төлөвлөлт

№	Сургалтын агуулга	Хугацаа	Хамрах хүрээ	Багшийн тайлбар
1	Хоолой дасгал	Өвлийн сургалт 2022-1-3-ноос 1-23 хүртэл хичээллэнэ	Дээрх сжралцагчид буюу 16-34 насны хоорондох дунд, ахлах ангийн сурагч, оюутан, ажилтан, жүжигчид байна.	Энэ хугацаанд хүүхдүүдийн хоолой тавил тэгширч, өнгө тогтол сайжирч, амьсгалын хуваарилалт болж, дуугаа илэрхийлэн чадвар сайжирсан.
2	Уухай			
3	БэУД, Дөрвөн настай халиун			
4	Хөх мөнгөн тэнгэр			
5	Цаст цагаан уул			
6	Жороо бор			
7	Дөрвөлжиндөө зуссан нь			
8	Их нарны гэрэл			
9	Дэлгэр сайхан хангай			
10	Дэлгэр сайхан хангай			
11	Нарийн шарга			
12	Нарийн шарга			
13	Цомбон туурайтай хүрэн			
14	Цомбон туурайтай хүрэн			
15	Эзэн богдын 2 загал			
16	Эзэн богдын 2 загал			
17	Алаг морь			
18	Алаг морь			
19	Авралын дээд			
20	Авралын дээд			
21	Дүгнэлт хичээл			

Илтгэгч Жимсээ миний бие энэхүү төлөвлөлтийнхөө дагуу сүүлийн 5 жил тасралтгүй Дөрвөд ардын дууны сонгоны сургалтыг ӨМӨЗО-ны Дөрвөд хошуундаа хүүхэд залуучуудын сонирхолын дагуу хичээллүүлж байна. Түүний үр дүнгийн хэсгээс харуулбал:

Дуулах сонгоны сургалтаар дээрх хүүхдүүд амжилттай төгсөж, мэргэжлийн анхан шатны боловсрол олох, мэргэжлээ дээшлүүлэх, Гандиг, Даланцэцэг, Хишигбуян нар орон аймгийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилттай оролцож, эхний байруудад шалгарч байсан ба Алиа, Дулаанаа хоёр тус тус Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн уртын дууны салбар, Шилийн голын Ажил мэргэжлийн дээд сургуулийн дуу хөгжмийн ангид элсэн орсон байна. Аснаа, Эрдэм, Энхзаяа, өндөр зэргийн дээд сургуульд урлагийн авьяаслаг сурагчаар шалгарч оржээ.

### Судалгааны үр дүн

Дөрвөд хошууны Монгол дундад суруулийн өндөр дэсийн багш Гэнсгэдалай нь сурлагын жилийн доод хугацаа буюу хаврын улиралд сургалтын хөтөлбөрийн дагуу агуулгын алдагдалгүйгээр Дөрвөд ардын “ Дорно дахины сувд”, “Үүлэн доторх цайз”, “Чидун мод” ..зэрэг 6 дууг сонгон зааж сургаснаар сургууль, хүүхэд, эцэг эх, багш нарт өндөрөөр үнэлэгдсэн. Дууг заахдаа дуулах үйл ажиллагааны үйлээр багшийг сонсох, бие биенээ сонсох, үгийн утгыг тайларлах, даган дуулах, хамтаар дуулах зэрэг аргуудыг хэрэглэсэн.Тухайлбал:

- Багш өөрөө дуулж үгийн хуваарийг сонсож, амьсгаа авах хэсэгт тэмдэглэгээ хийлгэх

- Дууны аялгууны хурд, хэмжээг тохируулан дуулах зэргийг анхааруулах
- Дууныхаа аяыг мөр мөрөөр нь дагуулан дуулуулж сургах
- Дууны үг аялгууг сайн сурсны дараа хэмжээ хэмнэлд нь тохируулан хөдөлгөөн хийж бүжиглэн дуулах
- Дууны утга агуулгыг дүрслэн зурж, өнгө будгаар ялгах
- Дууг анги хамт олноороо, хамтлагаар, гоцлолоор зөв сайхон дуулж, бүжиглэх гэх мэт. Үр дүнг дараах судалгаагаар харуулбал:

Хүснэгт 1: Дөрвөд хошууны Монгол үндэстний дунд сургуулийн 8а ангийн сурагчдын Дөрвөд ардын дууг хэрхэн сурсан судалгаа / 1-5оноо/

№	Суралцагчдын нэрс	Дээд				1-р хагасын үнэлгээ	Доод			2-р хагасын үнэлгээ
		Ардын дууны дуулах арга барил онол	Хөх мөнгөн тэнгэр	Цаст цагаан уул	Дөрвөлжиндөө зуссан нь		Жороо бор	Дэлгэр сайхан хангай	Их нарны гэрэл	
1	Аварга	4	3	3	4	10	3	4	4	11
2	Алиа	5	4	4	4	12	4	5	5	14
3	Аснаа	5	3	4	5	12	4	5	5	14
4	Баатар	4	2	4	4	10	4	4	5	13
5	Батжаргал	3	3	3	4	10	4	4	5	13
6	Баяраа	4	4	4	4	12	4	5	5	14
7	Бүрэн	3	3	4	4	11	4	4	4	12
8	Гэгээнзул	3	4	4	4	12	4	4	4	12
9	Гэгээнцэр	4	4	4	4	12	4	5	5	14
10	Гэрэлт	3	3	4	4	11	4	4	5	13
11	Гэндэнжав	4	4	4	5	13	5	5	5	15
12	Давхарбаяр	4	4	4	4	12	5	5	4	14
13	Далантай	3	3	4	4	11	4	4	4	12
14	Дуулим	3	3	4	4	11	4	4	4	12
15	Дулаанаа	4	4	4	5	13	5	5	5	15
16	Дэлгэр	4	3	4	4	11	4	4	4	12
17	Жимсээ	5	4	4	5	13	5	5	5	15
18	Заяа	3	3	3	4	10	4	4	4	12
19	Жаргал	4	2	3	4	9	3	4	4	11
20	Мандах	4	4	5	5	14	4	5	5	14
21	Налайнаа	5	5	5	5	15	5	5	5	15
22	Намараа	3	3	3	4	10	4	4	4	12
23	Саруул	4	4	4	4	12	4	4	5	13
24	Сайханаа	4	3	4	5	12	5	5	5	15
25	Эрдэм	5	4	4	5	13	5	5	5	15
26	Энхзаяа	5	5	4	5	14	5	5	5	15
Бүгд оноо		130	130	130	130	390	130	130	130	390
Авсан оноо		102	91	101	111	305	110	117	120	347

Дөрвөд ардын дууны онцлог, дуулах зан үйл, арга барилаас судалсан зүйлдээ тулгуурлан хүүхдийн нас сэтгэхүй онцлогт тохируулан 8-р ангид ардын дууг хэрхэн заах, дуулуулж сургах, өвлүүлэн үлдээх боломжийг харгалзан онцлон ажилласан болно. Эндээс харахад Дөрвөд ардын дууг сонгож дуу хөгжмийн хичээлээр заахад хүүхдүүд сайн сурч байна. Мөн цаашид ардын сурсан дуугаа мартаггүй нэгэн насны өв болно гэж үзлээ. Дөрвөд ардын дууны өвлөн уламжлагч Улсын хоёрдугаар

дэсийн тоглогч, уртын дууны багш Жимсээ өөрийн сургалтын хүрээнд энэхүү судалгааг хийсэн юм.

Хүснэгт 2 Жимсээгийн “Ардын дуу дуулах арга зүй” хичээлийн хөтөлбөр /дамжаа-1/

№	Сургалтын агуулга	Хугацаа	Хамрах хүрээ	Багшийн тайлбар
1	Хөгжмийн онолын хэллэг нэр томьёо	Зуны сургалт 2021-7-12-ноос 8-р сарын 1 хүртэл хичээллэнэ	16-34 насны хоорондох дунд, ахлах ангийн сурагч, оюутан, ажилтан, жүжигчид байна.	Энэхүү 21 хоногийн хугацаанд 16-34 насны 9 хүүхдүүдийн ирц, идэвх оролцоо сайн байж амжилттай суралцсан.  Иймээс 2-р шатны дамжаанд бүгд суралцахаар дахин гүнзгийрүүлэн хичээллэсэн.
2	Хөгжмийн хэм хэмнэл			
3	Хувиргалын тэмдэг			
4	Хүчдэлийн тухай			
5	Хэллэг хөгжүүлэх дасгал			
6	Амьсгал хөгжүүлэх дасгал			
7	Ардын дууны ач холбогдол			
8	Ардын дууны өв тээгчдийн намтар түүх			
9	Хоолойн багтаамж, өнгө тогтоох дасгал			
10	Уухай			
11	Нугалаа хийх дасгал			
12	Хоолойн цараа хөгжүүлэх дасгал			
13	Ардын дууны төрөл ангилал			
14	Ардын богино дуу дуулах арга зүй			
15	Ардын богино дуу дуулах арга зүй-Урын сантай ажиллах			
16	Урын сантай ажиллах			
17	Бэсрэг уртын дуутай ажиллах арга зүй			
18	БУД, Дөрвөн настай халиун			
19	БУД, Дөрвөн настай халиун			
20	Хөх мөнгөн тэнгэр			
21	Хөх мөнгөн тэнгэр			

Хүснэгт 3: 2-р дамжааны сургалтын төлөвлөлт

№	Сургалтын агуулга	Хугацаа	Хамрах хүрээ	Багшийн тайлбар
1	Хоолой дасгал	Өвлийн сургалт 2022-1-3-ноос 1-23 хүртэл хичээллэнэ	Дээрх сжралцагчид буюу 16-34 насны хоорондох дунд, ахлах ангийн сурагч, оюутан, ажилтан, жүжигчид байна.	Энэ хугацаанд хүүхдүүдийн хоолой тавил тэгширч, өнгө тогтол сайжирч, амьсгалын хуваарилалт болж, дуугаа илэрхийлэн чадвар сайжирсан.
2	Уухай			
3	БэУД, Дөрвөн настай халиун			
4	Хөх мөнгөн тэнгэр			
5	Цаст цагаан уул			
6	Жороо бор			
7	Дөрвөлжиндөө зуссан нь			
8	Их нарны гэрэл			
9	Дэлгэр сайхан хангай			
10	Дэлгэр сайхан хангай			
11	Нарийн шарга			
12	Нарийн шарга			
13	Цомбон туурайтай хүрэн			
14	Цомбон туурайтай хүрэн			
15	Эзэн богдын 2 загал			
16	Эзэн богдын 2 загал			
17	Алаг морь			
18	Алаг морь			
19	Авралын дээд			
20	Авралын дээд			
21	Дүгнэлт хичээл			

Иийнхүү сүүлийн 5 жил тасралтгүй Дөрвөд ардын дууны сонгоны сургалтыг ӨМӨЗО-ны Дөрвөд хошуундаа хүүхэд залуучуудын сонирхолын дагуу хичээллүүлж байгаа бөгөөд үүний үр дүнгийн хэсгээс харуулбал:

Дуулах сонгоны сургалтаар дээрх хүүхдүүд амжилттай төгсөж, мэргэжлийн анхан шатны боловсрол олох, мэргэжлээ дээшлүүлэх, Гандиг, Даланцэцэг, Хишигбуян нар орон аймгийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилттай оролцож, эхний байруудад шалгарч байсан ба Алиа, Дулаанаа хоёр тус тус Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн уртын дууны салбар, Шилийн голын Ажил мэргэжлийн дээд сургуулийн дуу хөгжмийн ангид элсэн орсон байна. Аснаа, Эрдэм, Энхзаяа, өндөр зэргийн дээд сургуульд урлагийн авьяаслаг сурагчаар шалгарч оржээ.

## Дүгнэлт

Дөрвөд ардын дууны аялгууны онцлог шинжийг тандан илрүүлэх зорилгоор сонгосон дуунуудын бүтцэд хийсэн судалгаандаа тулгуурлан, Дөрвөд ардын дууны аялгууны дараах онцлог шинжүүдийн илрүүлэн гаргасан болно. Үүнд:

1. Дөрвөд ардын дуу дуулагдахдаа уулархаг болон тал нутгийн аялгуучилсан хэлбэрийг хадгалсан нь хэл ярианыхаа онцлогийг аялгуундаа тодотгож байгаагаар илэрхийлэгддэг мэт ажиглагдаж байна.
2. Дөрвөд ардын дууны аялгууны хөгжилт ихэвчлэн аажуу ба үсрэлттэй холын интервал харьцангуй багатай байна. Тухайлбал: “Хөх мөнгөн тэнгэр” дуунд 1-р октавын ля ноотноос 2-р октавын ля ноот хүртэл нэг бүтэн октавын интервалаар үсэрч байгаа нь Халх уртын дууг бодвол харьцангуй бага нугалаа, хугалаатай үсрэлттэй, шуранхай бараг тохиолдохгүй байна.
3. Дөрвөд ардын дууны хүчтэй хувь нь үгийн эхэнд бас төгсгөлд илүү тод байдаг нь Дөрвөд аялга, хэл ярианых нь бүтэцтэй шууд холбоотой гэж үзлээ.
4. Дөрвөд ардын дууг дуулагдах байдал, утга санаанаас хамаарч гол төлөв дээрээс нь доош нь гулсуулах “Глиссандо” маягаар өрөг хоорондын шилжилтийг хийж байна.
5. Дөрвөд ардын дуу нь пентатоник таван өргийн ладанд суурилж байна. Диатоник буюу хагас өрөг огт тохиолдохгүй байна.

Дээрх судалгаа, сургалтын үйл ажиллагааны үр дүн зэргийг харгалзан бидний дэвшүүлэх санаа бол Монгол дунд сургуулийн дуу хөгжмийн сургалтын хөтөлбөрт сайн дураар /сонголтоор/ ардын дуунуудыг хүүхдийн нас сэтгэхүй, хоолойн багтаамжид тохируулан зааж байх нь дан дөрвөд гэхгүй ардын дууны өв уламжлалаа мартахагүй өвлүүлэн сургаж явах ач холбогдолтой гэж үзэж байна. Мөн Дөрвөд ардын дууны сайн дурын сонгон дугуйлангуудад хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулан сургах нь ардын дуугаа сурах, мэргэжлээ сонгох, өв соёлоо хадгалж үлдэх, дэлгэрүүлэн суралцах, үр дүнтэй ажил болно.

Бидний энэхүү “Дөрвөд ардын дууны онцлог, арга зүйн судалгаа” нь дөрвөд ардын дуугаа сурах, сургах, өвлүүлэн үлдээх, судлаач болон багш хэн бүхэнд гарын авлага болох ач холбогдолтой.

## Ном зүй


- Баасансүрэн, Т. (2001). Ховд аймгийн хураангуй толь бичиг. – Улаанбаатар
- Баярт, (2001). Дөрвөд хошууны боти- тал нутгийн нүүдэл, малжилын соёлын тэмдэг, цуврал бичиг”, Өвөр Монголын хэвлэлийн хороо
- БНМАУ-ын угсаатан судлал: 2 боть. 2011.– Улаанбаатар
- Вандуй, Э. (1965). Дөрвөд аман аялгуу. – Улаанбаатар
- Катуу, Б. (1996). “Дөрвөд ардын тууль” Улаанбаатар
- Катуу, Б. (2005). Дөрвөд ардын найрын болон богино дуу. – Улаанбаатар
- Катуу, Б. (2017). Дөрвөд аман зохиолын чуулган – Улаанбаатар
- Мияажав, С. (2004). Дөрвөд ардын дуу. – Улаанбаатар
- Нямбуу, Х. (1992). Монгол угсаатны зүй, Улаанбаатар
- Очир, А. (1993). Монголын Ойрадуудын түүхийн товч. – Улаанбаатар
- Орих, З. (2016). Дөрвөд хуримлах ёсны дуу хөгжмийн онцлог.- Улаанбаатар
- Өвөрмонголын хэвлэлийн хороо, 1979. Монгол ардын дуу 500 дээд дэвтэр
- Сүхбат,Ш., Нарантуяа, Ш. (2011). Алаша, Баяд, Дарьганга, Дөрвөд, Жалайрд уртын дуу-II. Улаанбаатар
- Цолоо Ж. 2004. Дөрвөд ардын дуу. – Улаанбаатар
- Энэбиш, Ж.(2008), Монголын хөгжим судлалын дээж бичиг. Соёмбо принтинг, Улаанбаатар

## RESEARCH ON CHARACTERISTICS AND METHODS OF INHERITANCE OF DURVUD FOLK SONGS

JIMUSI<sup>a</sup>, Ch.Otgonbayar<sup>b</sup>

<sup>a</sup>China, Inner Mongolia, Education Bureau of Durvud khoshuu Ulaantsav;

<sup>b</sup>Ph.D, Lecturer, Teachers school, MNUE

Corresponding author: Wechat ID: wxid\_kf17lylnua2s22, otgonbayar.ch@msue.edu.mn 

### Abstract

Durvud is one of the ancient Mongolian ethnic groups and forest dwellers. Oirad is the main province of the East Hand Kingdom and the dominant province of Khovd Khyrek during the Bogd Khanate Mongol period. Durvud - Yastan of Mongolian origin, Mongolian speaking with Oirad dialect. Durvud was one of the four main provinces of the Durvud Oirads, established between 1400 and 1755. There are Durvud bones in mass in Dachin City (a city opposite the province) of the Black Sea Province of China (the province between Inner Mongolia, Vladivostok of the Russian Federation, and the Republic of Korea) in the Autonomous Prefecture of Durvud Mongolia (north-western part of the province), and these four It is believed to have been cut off when they migrated from the Yenisei River to the Khalkh River and Lake Baikal in the 11th century and moved to the west. In addition, there are four tribes living among the Khoshuud Mongols in Inner Mongolia's Ulaantsav city (about 18,000 people) and Hoshuud Mongolians (about 18 thousand).

### Keywords

Durvud folk songs, culture, research, training and results

---